лоо хоног тутмын хэвлэл
0 оны 11 дүгээр сарын 18
№43 /664/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



**Монгол Улсын Их Хурлын тогтоол**

1711

## Байнгын хорооны гишүүнээр батлах тухай

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг**

1712

## Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

**Монгол Улсын Засгийн газрын тогтоол**

1723

## Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай

Улаанбаатар хот
2010 он

Улсын Их Хурлын Тамгын Газар

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

372. Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 50 1710

373. Байнгын хорооны гишүүнээр батлах тухай Дугаар 56 1711

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

374. С.Батдэлгэрийг албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 221 1711

375. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 233 1712

376. Ц.Зоригийг албан тушаалд томилох тухай Дугаар 234 1712

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

377. Төлөвлөгөө батлах тухай Дугаар 222 1713

378. "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" тэмдэг бий болгох тухай Дугаар 236 1723

379. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 239 1723

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

380. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 05 1730

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот

**Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоож, 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоолыг 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

**Монгол Улсын Их Хурлын 2010 оны 50 дугаар тогтоолын хавсралт**

### ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТАН БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ АЛБАН ТУШААЛТНЫ АЛБАН ТУШААЛЫН САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

| № | Албан тушаалын зэрэг, дэв | Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1 | ТӨ-I /Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хориг тавьсан/ | 1424435 |
| 2 | ТӨ-II | 1073630 |
| 3 | ТӨ-III | 826563 |
| 4 | ТӨ-IY, ТӨ- IY A | 792819 |
| 5 | ТӨ-Y, ТӨ- Y A | 734352 |
| 6 | ТӨ-YI, ТӨ- YI A | 700441 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 56 | Улаанбаатар хот

**Байнгын хорооны гишүүнээр батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн С.Баярыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 10 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 221 | Улаанбаатар хот

**С.Батдэлгэрийг албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 4, Шүүхийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Содномдаржаагийн Батдэлгэрийг чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргасныг нь үндэслэн Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр | Дугаар 233 | Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Катар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чойжилжавын Болдыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Катар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Кадырын Сайрааныг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр | Дугаар 234 | Улаанбаатар хот

**Ц.Зоригийг албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 16, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын Дээд шүүхийн санал болгосноор Тугчин овогт Цэвэгмидийн Зоригийг Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр | Дугаар 222 | Улаанбаатар хот |

**Төлөвлөгөө батлах тухай**

"Монгол мал" үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн эхний үе шат (2010-2015 он)-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлагсугай.

2. "Монгол мал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн биелэлт, үр дүнг нэгтгэн, жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **С.БАТБОЛД**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД** — **Т.БАДАМЖУНАЙ**

Засгийн газрын 2010 оны 222 дугаар
тогтоолын хавсралт

## "МОНГОЛ МАЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ҮЕ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2010-2015 ОН)

| Чиглэл | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа (он) | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|
| 1. Мал аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох | | | | |
| 1.1. Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох | 1.1.1. Бэлчээрийн тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх | 2010-2011 | ХХААХҮЯ | ХЗДХЯ |
| | 1.1.2. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | 2010-2012 | ХХААХҮЯ | ХЗДХЯ |
| | 1.1.3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эдийн засгийн урамшуулал бий болгох асуудлыг судалж тодорхой санал боловсруулах | 2011-2012 | ХХААХҮЯ | ХЗДХЯ, олон улсын байгууллага |
| | 1.1.4. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | 2011-2012 | ЗТБХБЯ | ХЗДХЯ |
| | 1.1.5. Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | 2011-2012 | ЗТБХБЯ | ХХААХҮЯ, олон улсын байгууллага |
| | 1.1.6. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | 2011-2012 | СЯ | ХЗДХЯ |
| | 1.1.7. Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | 2011-2012 | ХХААХҮЯ | ХЗДХЯ, ОБЕГ |
| | 1.1.8. Малын эмч, мал зүйч нарыг мэргэжлээс шалтгаалах өвчний болон хүнд нөхцөлд ажиллаж байгаа бүлэгт хамруулах эрх зүйн орчинг бий болгох | 2010-2012 | НХХЯ | ХХААХҮЯ |
| | 1.1.9. "Мах" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх | 2010-2015 | ХХААХҮЯ | ҮХЩХ, СХЗГ, МХЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, Мах үйлдвэрлэгчдийн холбоо |
| | 1.1.10. "Тэмээ" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | ҮХЩХ, СХЗГ, МХЕГ, аймгийн Засаг дарга |
| | 1.1.11. "Арьс шир" дэд хөтөлбөрийг боловсруулж | 2011-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ, ҮХЩХ, аймаг, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх | | | нийслэлийн Засаг дарга, Арьс, шир үйлдвэрлэгчдийн холбоо |
| | 1.1.12. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг боловсруулж Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх | 2010-2011 | ХХААХҮЯ | ХЗДХЯ |
| | 1.1.13. Нийслэл, томоохон суурин газрын орчимд сүүний аж ахуй хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | 2011-2014 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | ХХААХҮЯ |
| 1.2. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэх | 1.2.1. Сумдад мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний анхан шатны нэгжийг шинээр бий болгох асуудлыг шийдвэрлүүлэх | 2010 | ХХААХҮЯ | СЯ, аймгийн Засаг дарга |
| | 1.2.2. Сумдын мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааны чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | 2010-2011 | ХХААХҮЯ | СЯ, аймгийн Засаг дарга |
| | 1.2.3. Сумдын мал эмнэлэг, үржлийн нэгжийн болон мал эмнэлэг, үржлийн чиглэлээр ажил, үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшлийн үйл ажиллагаанд тавигдах стандарт, чиг үүргийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж батлуулж мөрдөх | 2011 | ХХААХҮЯ | Аймгийн Засаг дарга |
| | 1.2.4. Мал эмнэлэг, үржлийн 1-2 загвар нэгжийг эхний ээлжинд аймаг бүрт бий болгох | 2011-2014 | МЭҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга | ХХААХҮЯ |
| | 1.2.5. Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын талаарх мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан бий болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулах | 2011-2012 | ХХААХҮЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 1.2.6. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний хяналтыг сайжруулах, малын эмч, мал зүйчдийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох | 2010-2015 | МХЕГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 1.2.7. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ явуулах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байх | 2012-2015 | Бүх шатны Засаг дарга | МЭҮГ |
| 1.3.Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг | 1.3.1. Мал аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг төлөвлөгөөтэй зохион байгуулах | 2010-2012 | ХХААХҮЯ | БСШУЯ, аймгийн Засаг дарга |
| | 1.3.2. Малчдад бэлчээрийн мал маллагааны уламжлалт | 2010-2015 | | ХААИС, ХААҮШУОНТ, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| боловсролыг дээшлүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх | болон дэвшилтэт арга технологи эзэмшүүлэх, аж ахуйгаа үр ашигтай хөтлөх мэдлэг олгох зайны болон орон нутгийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | - | ХХААХҮЯ | аймгийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| | 1.3.3. Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологийн болон инновацийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх | 2010-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ, ХААҮШУОНТ, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 1.3.4. Мал эмнэлэг, үржлийн загвар аж ахуй, мэргэжлийн баг, нэгж бий болгож, шинжлэх ухааны ололт, инноваци үйлдвэрлэлд нэвтрүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ, ХААҮШУОНТ, аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| | 1.3.5. Малын эмч, мал зүйч хос мэргэжил эзэмшүүлэх, мэргэжилтнийг давтан сургах замаар малын эмч, мал зүйч мэргэжлээр хөрвөх чадвар эзэмшүүлэх | 2011-2012 | БСШУЯ | ХХААХҮЯ |
| 2. Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах | | | | |
| 2.1. Малын чанар, ашиг шимийг сайжруулах | 2.1.1. Цөм сүргийн малыг үржүүлж, чанар, стандартын шаардлага хангасан үр, хээрэл үр үйлдвэрлэх үүсгэл санаачилгыг дэмжих | 2011-2012 | ХХААХҮЯ | СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 2.1.2.Монголд үржүүлж байгаа баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимийн түвшинг судлан тогтоож, зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үржил-селекцийн ажил зохион байгуулах | 2010-2015 | ХХААХҮЯ | МЭҮГ, МААЭШХ |
| | 2.1.3. Арвин ашиг шимт хээлтүүлэгч малын үр, хээрэл үр, биотехнологийн дэвшилтэт аргыг хэрэглэж бүтээмжийг дээшлүүлэх | 2010-2011 | ХХААХҮЯ | МЭҮГ, МААЭШХ, МЭҮХ |
| | 2.1.4. Сүү, махны чиглэлийн үхэр, нарийн нарийвтар ноост болон хурганы арьсны чиглэлийн хонь зэрэг төрөлжсөн үүлдрийн, бүтээмж өндөртэй мал үржүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | МЭҮГ, МААЭШХ |
| | 2.1.5. Сүүний чиглэлийн үнээний зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг нийслэл болон томоохон хотуудын орчимд байгуулж ажиллуулах | 2011-2013 | МЭҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга | ХХААХҮЯ, МААЭШХ |
| 2.2. Малын удмын санг хамгаалах | 2.2.1. Малын удмын сангийн үндсэний цөцөлборыг байгуулах асуудлыг судлах | 2012-2013 | ХХААХҮЯ | СЯ, ЗТБХБЯ, МЭҮГ |
| | 2.2.2. Тоо нь цөөрч байгаа үүлдэр, омог болон гойд ашиг шимтэй малын удмын санг хамгаалах, зохистой ашиглах, | 2011-2015 | ХХААХҮЯ | Аймгийн Засаг дарга |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | үрийг нь хадгалах ажлыг зохион байгуулах | | | |
| | 2.2.3. Улсын хилээр үржлийн мал амьтан, тэдгээрийн үр, хээрэл үр, өндгөн эсийг нэвтрүүлэх ажлыг нэгдсэн бүртгэл, хяналттай болгох | 2011-2012 | ХХААХҮЯ, МХЕГ | ГЕГ, МЭҮГ |
| | 2.2.4. Бүсийн төвүүдэд үржил-биотехнологийн нэгжтэй болгох, технологи дамжуулах, нутагшуулах, зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ бий болгох | 2012-2013 | ХХААХҮЯ | Аймгийн Засаг дарга |
| | 2.2.5. Малын чанар сайжруулах зорилтот ажил, үйлчилгээг үүлдрийн нийгэмлэг зэрэг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | СЯ, БСШУЯ, НХХЯ, Мэргэжлийн холбоо, зөвлөл |
| 2.3. Малын үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах | 2.3.1. Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний анхан шатны нэгжийн үйл ажиллагааны стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах | 2010-2011 | ХХААХҮЯ | СХЗГ, МЭҮГ |
| 2.4. Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох | 2.4.1. Мал сүргийг бүртгэх ажлыг цөм сүргээс эхлэн үе шаттай хэрэгжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх | 2010-2011 | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | ХЗДХЯ, ҮСХ, МЭҮГ |
| | 2.4.2. Малын бүртгэлийн нэгдсэн программыг нэвтрүүлэх ажлыг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж, энэ чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах | 2010-2011 | ХХААХҮЯ | МЭҮГ, олон улсын байгууллага, ТББ мэргэжлийн холбоод |
| | 2.4.3. Малын бүртгэлийн ажил, үйлчилгээ хариуцсан ажилтанг сургах, тэдгээрийг шаардлагатай программ хангамж, техник хэрэгсэл, багаж тоноглолоор хангах ажлыг зохион байгуулах | 2011-2013 | ХХААХҮЯ | СЯ, МЭҮГ, олон улсын байгууллага |
| | 2.4.4. Мал аж ахуй эрхэлж байгаа малчин өрх, байгууллагын мал эмнэлэг, үржлийн ажлын анхан шатны бүртгэл, бүтээгдэхүүний гарал, үүслийг тодорхойлох стандарт боловсруулах | 2011-2012 | МЭҮГ | ХХААХҮЯ, СХЗГ |
| 3. Малын эрүүл мэндийг хамгаалах | | | | |
| | 3.1.1. Монгол Улсыг ухрийн цээж өвчингүй, баруун бүсийн аймгуудыг малын гоц халдварт шүлхий өвчний вакцин хэрэглэдэггүй эрүүл бүс нутгийн статусыг Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагаар баталгаажуулж, хяналтын болон хамгаалалтын бүс байгуулах | 2010-2012 | ХХААХҮЯ | ХЗДХЯ, ГХЯ, СЯ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.1. Малын гоц халдварт, халдварт өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх | 3.1.2. Шүлхий болон хонь, ямааны цэцэг өвчний голомттой бус нутаг дахь урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах замаар тархалтыг зогсоож, хамрах хүрээг багасгах | 2010-2012 | ХХААХҮЯ | МХЕГ, аймгийн Засаг дарга |
| | 3.1.3. Баруун бүсийн аймгуудын шүлхийн халдваргүй бүс нутгийн статусыг хадгалах, мал эмнэлгийн тандалт, хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 2010-2012 | ХХААХҮЯ | МХЕГ, аймгийн Засаг дарга |
| | 3.1.4. Мал сүргийг бруцеллёз, ям, сүрьеэ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг Завхан, Сүхбаатар аймгаас эхлэн хэрэгжүүлэх | 2010-2015 | ХХААХҮЯ | СЯ, ЭМЯ, аймгийн Засаг дарга |
| | 3.1.5. Дотоод, гадаад худалдаа, хүн амын эрүүл мэндэд нөлөөлдөг халдварт өвчний тархалтыг улсын хэмжээнд нарийвчлан тогтоох, нийтэд мэдээлэх | 2010-2011 | ХХААХҮЯ | БСШУЯ |
| | 3.1.6. Аймгийн мал эмнэлэг, үржлийн албадын шуурхай дуудлагын болон ариутгал, халдваргүйтгэлийн автомашин, тоног, төхөөрөмжийн хангамжийг сайжруулах | 2011-2012 | ХХААХҮЯ | СЯ |
| | 3.1.7. Шинээр гарч байгаа болон дахин сэргэж байгаа, хил дамжин халдварладаг гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөг аймаг, сумын түвшинд боловсруулж хэрэгжүүлэх | 2010-2011 | ХХААХҮЯ | ОБЕГ, МХЕГ, аймгийн Засаг дарга |
| | 3.1.8. Байнгын ажиллагаатай хилийн бүх боомтод мал, малын гаралтай түүхий эд тээвэрлэх автотээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, халдваргүйтгэл хийх иж бүрэн цогцолбор байгуулах | 2011-2013 | ГЕГ, МХЕГ | ХХААХҮЯ, СЯ |
| | 3.1.9. Орон нутгийн эндемик өвчнүүдээс мал сүргийг хамгаалах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ, БОАЖЯ, ЭМЯ |
| 3.2. Мал эмнэлгийн албаны тогтолцоог боловсронгуй болгох | 3.2.1. Зарим аймгийн мал эмнэлгийн лабораторийг иж бүрэн шинэчлэх, бүсийн төвүүдэд мал эмнэлгийн оношилгооны лаборатори байгуулах | 2011-2014 | ХХААХҮЯ | СЯ, аймгийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| | 3.2.2. Сум дундын мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний явуулын лаборатори байгуулах | 2011-2015 | ХХААХҮЯ | СЯ, аймгийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| | 3.2.3. Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг сумын түвшнээс эхлэн олон улсын стандарт, арга зүйн дагуу гүйцэтгүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ |
| | 3.2.4. Байгалийн голомтот болон дахин сэргэж байгаа | 2010-2015 | ХХААХҮЯ | СЯ, аймгийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | малын өвчний тархвар, голомтыг нэгбүрчлэн бүртгэн мэдээлэх, газар зүйн мэдээллийн (GIS) тогтолцоог аймаг, сумын түвшинд бий болгох | | | Засаг дарга, олон улсын байгууллага |
| 3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын стандартын түвшинд хүргэх | 3.3.1. Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 2011-2013 | ХХААХҮЯ | СЯ, олон улсын байгууллага |
| | 3.3.2. Хуурамч эмийг зах зээлд борлуулах ажлыг таслан зогсооход чиглэсэн хяналтыг сайжруулах | 2011-2012 | ХХААХҮЯ | МХЕГ |
| | 3.3.3. "Биокомбинат" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт технологийн шинэчлэл хийж, олон улсын чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх | 2010-2012 | ХХААХҮЯ | СЯ, олон улсын байгууллага |
| | 3.3.4. Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоо, сүлжээг бий болгох, тадгаэрийг дэмжих | 2011-2014 | ХХААХҮЯ | МҮХАҮТ |
| 4. Байгалийн эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх | | | | |
| 4.1 Бэлчээрийн менежментийг сайжруулах | 4.1.1. Бэлчээрийн ашиглалт, кадастрын зураглалыг аймаг, сум тус бүрээр гаргах, мэдээллийн санг бий болгох | 2011-2012 | ЗТБХБЯ | ХХААХҮЯ, олон улсын байгууллага |
| | 4.1.2. Бэлчээрийн даац, багтаамжийг аймаг, сум тус бүрээр нарийвчлан судалж шинэчлэн тогтоох | 2011-2013 | ХХААХҮЯ | БОАЖЯ, БСШУЯ, олон улсын байгууллага |
| | 4.1.3. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулдаг мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга, технологиор тэмцэх ажлыг зохион байгуулах | 2011-2015 | ХХААХҮЯ | Аймгийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| | 4.1.4. Малын тэжээлийн ургамал тариалах талбай, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх талаар гарын авлага гаргаж нийтийн хүртээл болгох, сурталчлах | 2011-2012 | ХХААХҮЯ | Олон улсын байгууллага |
| | 4.1.5. Отрын нөөц бэлчээрийг ашиглах журмыг боловсруулах | 2011 | ХХААХҮЯ | Аймгийн Засаг дарга |
| | 4.1.6. Аймаг дундын болон сум дундын отрын бүс нутгийг шинээр бий болгох, хамгаалах, судалгаа хийх | 2011-2015 | ХХААХҮЯ | Аймгийн Засаг дарга |
| | 4.1.7. Сум бүр бэлчээрийн болон эрсдэлийн удирдлагын жилийн төлөвлөгөөг малчид, иргэдийн оролцоотойгоор боловсруулан хэрэгжүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | ГХХБГ, аймгийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| 4.2. Хадлан тэжээлийн | 4.2.1. Сум дундын малын тэжээлийн нөөцийн цэг бий болгох ажлыг зохион байгуулах | 2010-2012 | ХХААХҮЯ | СЯ, аймгийн Засаг дарга, олон улсын байгууллага |

| | | | | |
|---|---|---|---|---|
| үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх | 4.2.2. Хадлангийн талбайг хашиж өвс бэлтгэх төсөл хэрэгжүүлэх | 2010-2015 | ХХААХҮЯ | СЯ, олон улсын байгууллага |
| | 4.2.3. Хадлан бэлтгэх, тэжээл үйлдвэрлэх зориулалт бүхий техник, тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэх аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих | 2010-2011 | ХХААХҮЯ | СЯ, аймгийн Засаг дарга |
| | 4.2.4. Тэжээлийн нэг болон олон наст ургамлын үр үржүүлэх аж ахуйн нэгжийг бүсүүдэд байгуулж, үйл ажиллагаагаа нь дэмжих аялыг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлогын хүрээнд хэрэгжүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | 4.2.5. Уургийн агууламж ихтэй, өөр багатай, шинэ төрлийн тэжээл үйлдвэрлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл шалгаруулж, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ, олон улсын байгууллага |
| | 4.2.6. Говийн бүсийн аймгуудад тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 2011-2012 | БОАЖЯ | ХХААХҮЯ, аймгийн Засаг дарга |
| | 4.2.7. Тэжээлийн ургамал тариалах зориулалт бүхий талбайн усалтын хүчин системийг сэргээн засварлах, усан сан байгуулахад дэмжлэг үзүүлэх | 2010-2013 | ХХААХҮЯ | СЯ, олон улсын байгууллага |
| | 4.2.8. Отрын бүс нутагт усалгаатай болон хашаалсан талбайг бий болгож, олон наст тэжээлийн ургамал тариалж, ногоон тэжээл бэлтгэх, тэжээлийн үрийн нөөц бий болгох | 2010-2015 | ХХААХҮЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| 4.3. Малын усан хангамжийг сайжруулах | 4.3.1. Бэлчээрт инженерийн хийцтэй болон гар худаг гаргах, усан сан, хөв цөөрөм байгуулах стандартыг боловсруулах | 2010 | ХХААХҮЯ | СХЗГ |
| | 4.3.2. Ус дутагдалтай бэлчээр нутагт усны хайгуул хийх, бэлчээрийн усан хангамжийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох | 2010-2015 | ХХААХҮЯ | СЯ, ЗТБХБЯ, олон улсын байгууллага |
| | 4.3.3. Орон нутагт усан хангамжийг сайжруулах зорилгоор жил бүр 500-гаас доошгүй тооны инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, түүнд шаардагдах хөрөнгийн тодорхой хувийг хэрэглэгч-малчдаас гаргадаг болгох | 2010-2015 | СЯ | ХХААХҮЯ, олон улсын байгууллага |
| | 4.3.4. Цас, борооны усыг тогтоож, хөв цөөрөм байгуулах үйл ажиллагааг дэмжих | 2011-2015 | ХХААХҮЯ | БОАЖЯ |
| | 4.3.5. Өөрийн хөрөнгөөр гар худаг гаргах, усан сан байгуулах зэргээр малын усан хангамжийг сайжруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулан дэмжих | 2011-2015 | ХХААХҮЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын байгууллага |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.4. Мал аж ахуйн эрсдэлийг бууруулах чадавхи бий болгох | 4.4.1. Бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх арга технологийг боловсронгуй болгох чиглэлээр малчдад зориулан сургалт зохион байгуулах, сурталчлах | 2011-2012 | БСШУЯ | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| | 4.4.2. Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын хөдөлмөрийн зохион байгуулалтын хэлбэрүүдийг бүх талаар дэмжих | 2011-2015 | ХХААХҮЯ | НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| | 4.4.3. Малын хашаа саравч засах, бууц нөөцлөх ажлыг малчдын өөрсдийн хүч хөрөнгөөр зохион байгуулах | 2011-2012 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | - |
| | 4.4.4. "Малын индексжүүлсэн даатгал" төслийг бүх аймгуудад хэрэгжүүлж, нийт малчин өрхийн 15-аас доошгүй хувийг уг даатгалд хамруулах | 2010-2015 | СЯ | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| | 4.4.5. Байгалийн гамшиг тохиолдох үед үнэлгээ хийх, шуурхай тусламж үзүүлэх, сэргээн босгох, эрсдэлийг бууруулах бэлэн байдлын төлөвлөгөө гаргах | 2010-2012 | ОБЕГ | ХХААХҮЯ, олон улсын байгууллага |
| 5. Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох | | | | |
| 5.1. Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох | 5.1.1. Малын гаралтай түүхий эдийн стандартыг үнэлж, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах тухай асуудлаар олон улсын стандартыг судлан нэвтрүүлэх, сурталчлах | 2010-2015 | ХХААХҮЯ | МХЕГ, СХЗГ, аймгийн Засаг дарга |
| | 5.1.2. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгох | 2011-2013 | ХХААХҮЯ | СХЗГ, МХЕГ, аймгийн Засаг дарга |
| | 5.1.3. Сум бүрт мал нядалгааны болон арьс ширний анхан шатны цехийг байгуулах ажлыг жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хүрээнд дэмжих | 2011-2013 | ХХААХҮЯ | Аймгийн Засаг дарга |
| | 5.1.4. Мал, мах бэлтгэл болон технологийн тээвэр бүхий борлуулалтын нэгдсэн сүлжээ бий болгох | 2011-2015 | ХХААХҮЯ | ЗТБХБЯ, МХЕГ, аймгийн Засаг дарга |
| | 5.1.5. Малын дайвар бүтээгдэхүүний судалгааг гаргаж, ашиглалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2010-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ, МУХАҮТ |
| | 5.1.6. Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэл, хадгалалт, тээвэрлэлтийн чанар, стандартын талаархи сургалтыг жил бүр зохион байгуулах | 2011-2015 | ХХААХҮЯ | СХЗГ, МХЕГ, аймгийн Засаг дарга |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 5.1.7. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх | 2011-2013 | ХХААХҮЯ | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 5.2. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эдийн засгийн урамшуулал бий болгох | 5.2.1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эдийн засгийн урамшуулал бий болгосон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | 2012-2015 | ХХААХҮЯ | СЯ, Мэргэжлийн холбоод |
| | 5.2.2. Стандартад заасан ангилал, зэрэглэлийн дагуу түүхий эдэд ялгавартай үнэ тогтоох арга хэмжээ авах | 2012-2013 | ХХААХҮЯ | СЯ, МУХАҮТ |
| 5.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийг сайжруулах | 5.3.1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн суурь судалгааг 3 жил тутамд хийж, үр дүнг хэлэлцүүлэн, зөвлөмж гаргаж хэрэгжүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ, аймгийн Засаг дарга |
| | 5.3.2. Мал аж ахуйн бүтээгдэхүүний маркетингийн судалгааг жил бүр хийж, зорилтот зах зээлийг тогтоож, брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ, аймгийн Засаг дарга, Мэргэжлийн холбоод |
| | 5.3.3. Малчид, үйлдвэрлэгчид, эрдэм шинжилгээний байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих | 2010-2013 | ХХААХҮЯ | БСШУЯ, Мэргэжлийн холбоод |
| | 5.3.4. Газар зүйн заалтад хамаарах түүхий эдийг судалгаагаар тогтоож, түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ дэвшилтэт технологи боловсруулах, нутагшуулах үйл ажиллагааг дэмжих | 2011-2015 | ХХААХҮЯ | БСШУЯ |
| | 5.3.5. Газар зүйн заалттай бүтээгдэхүүнийг олон улсын холбогдох байгууллагад бүртгүүлэх | 2012-2013 | ХХААХҮЯ | Оюуны өмчийн газар, Мэргэжлийн холбоод |
| | 5.3.6. Түүхий эдийн нөөцийн хэмжээтэй уялдуулан ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратеги боловсруулан хэрэгжүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | СЯ |
| | 5.3.7. Малын паразиттах өвчнийг эмчлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сургийг технологийн дагуу хамруулж, үр дүнг нь бэлэн бүтээгдэхүүний чанараар тодорхойлдог тогтолцоог бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэн нэвтрүүлэх | 2011-2015 | ХХААХҮЯ | МХЕГ, аймгийн Засаг дарга, Мэргэжлийн байгууллагууд |

Тайлбар:

1. МЭҮГ-Мал эмнэлэг, үржлийн газар
2. ХААҮШУОНТ-Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төв
3. МААЭШХ-Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 236 | Улаанбаатар хот

**"Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" тэмдэг бий болгох тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад доор дурдсан агуулга бүхий 49 дэх заалт нэмсүгэй:

| | | |
|---|---|---|
| 49 | "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" тэмдэг | Монгол Улсын Тэргүүн шадар сайд |

2. "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" тэмдэг олгох журам, зааврыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН
ТЭРГҮҮН ШАДАР САЙД** **Н.АЛТАНХУЯГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 239 | Улаанбаатар хот

**Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28.4.3, 28.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 5 дугаар, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 6 дугаар, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 7 дугаар, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 8 дугаар, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод жишгийг 9 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталж, 2010 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 351 дүгээр тогтоолыг 2010 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,**
**ХӨДӨЛМӨРИЙН САЙД** **Т.ГАНДИ**

**Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт**

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТЗ-1 | ТЗ-2 | ТЗ-3 | ТЗ-4 | ТЗ-5 | ТЗ-6 | ТЗ-7 | ТЗ-8 | ТЗ-9 | ТЗ-10 | ТЗ-11 | ТЗ-12 | ТЗ-13 | ТЗ-14 |
| 1 | 209377 | 227565 | 248585 | 265157 | 280515 | 307245 | 337970 | 371767 | 408943 | 449838 | 472329 | 496553 | 521378 | 531807 |
| 2 | 225252 | 244819 | 267433 | 285262 | 301784 | 330541 | 363595 | 399955 | 439950 | 483945 | 508142 | 533795 | 560483 | 571692 |
| 3 | 241131 | 262077 | 286285 | 305371 | 323058 | 353842 | 389226 | 428149 | 470963 | 518060 | 543963 | 571161 | 599718 | 611712 |
| 4 | 256493 | 278773 | 304524 | 324825 | 343639 | 376384 | 414023 | 455425 | 500968 | 535601 | 554989 | - | - | - |
| 5 | 271852 | 295467 | 322759 | 344276 | 364217 | 398923 | 438815 | 482697 | 530966 | 553141 | 566014 | - | - | - |

**Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт**

## УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО БОЛОН ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | АА-11 | АА-10 | АА-9 | АА-8 | АА-7 | АА-6 | АА-5 | АА-4 | АА-3 | АА-2 | АА-1 |
| 1 | 265157 | 280515 | 307245 | 337970 | 371767 | 408943 | 449838 | 472329 | 496553 | 521378 | 531807 |
| 2 | 285262 | 301784 | 330541 | 363595 | 399955 | 439950 | 483945 | 508142 | 533795 | 560483 | 571692 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 305371 | 323058 | 353842 | 389226 | 428149 | 470963 | 518060 | 543963 | 571161 | 599718 | 611712 |
| 4 | 324825 | 343639 | 376384 | 414023 | 455425 | 500968 | 535601 | 554989 | - | - | - |
| 5 | 344276 | 364217 | 398923 | 438815 | 482697 | 530966 | 553141 | 566014 | - | - | - |

**Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт**

## ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТТ-1 | ТТ-2 | ТТ-3 | ТТ-4 | ТТ-5 | ТТ-6 | ТТ-7 | ТТ-8 | ТТ-9 | ТТ-10 | ТТ-11 | ТТ-12 | ТТ-13 | ТТ-14 | ТТ-15 | ТТ-16 | ТТ-17 | ТТ-18 |
| 1 | 183862 | 189948 | 208659 | 224596 | 230526 | 241823 | 253814 | 266610 | 279840 | 293937 | 308834 | 324066 | 340269 | 357282 | 375148 | 431417 | 452987 | 482046 |
| 2 | 198751 | 216426 | 238990 | 244327 | 250778 | 263067 | 276220 | 290031 | 304533 | 318760 | 335748 | 352535 | 370182 | 388670 | 408102 | 489317 | 492782 | 502637 |
| 3 | 212137 | 233351 | 244741 | 263434 | 270389 | 283639 | 297921 | 312712 | 328348 | 344765 | 362004 | 380104 | 399109 | 419084 | 440017 | 506018 | 531318 | 541944 |
| 4 | 226483 | 249131 | 261292 | 281248 | 288674 | 302820 | 317861 | 333859 | 350552 | 368080 | 386484 | 405808 | 426099 | 447404 | 469773 | - | - | - |
| 5 | 241262 | 265369 | 278343 | 299602 | 307512 | 322581 | 338710 | 355648 | 373428 | 392100 | 411785 | 432290 | 453904 | 476599 | 500428 | - | - | - |

Засгийн газрын 2010 оны 239 дүгээр
тогтоолын 4 дүгээр хавсралт

### ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮШУ-1 | ТҮШУ-2 | ТҮШУ-3 | ТҮШУ-4 | ТҮШУ-5 | ТҮШУ-6 | ТҮШУ-7 |
| 1 | 271298 | 360352 | 396387 | 428296 | 462560 | 499565 | 539530 |
| 2 | 274036 | 363988 | 400387 | 432579 | 467185 | 504559 | 544924 |
| 3 | 280992 | 373227 | 410550 | 443394 | 478868 | 517175 | 558548 |
| 4 | 298638 | 396666 | 424750 | - | - | - | - |
| 5 | 318324 | 422814 | 438949 | - | - | - | - |

Засгийн газрын 2010 оны 239 дүгээр
тогтоолын 5 дугаар хавсралт

### МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГУУЛИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТУМБ-1 | ТУМБ-2 | ТУМБ-3 | ТУМБ-4 | ТУМБ-5 | ТУМБ-6 | ТУМБ-7 | ТУМБ-8 | ТУМБ-9 |
| 1 | 271298 | 298428 | 313349 | 360352 | 396387 | 428296 | 462560 | 499565 | 539530 |
| 2 | 274036 | 301440 | 316512 | 363988 | 400387 | 432579 | 467185 | 504559 | 544924 |
| 3 | 280992 | 309091 | 324546 | 373227 | 410550 | 443394 | 478866 | 517175 | 558548 |
| 4 | 298638 | 328502 | 344927 | 396666 | 424750 | - | - | - | - |
| 5 | 318324 | 350157 | 367664 | 422814 | 438949 | - | - | - | - |

Засгийн газрын 2010 оны 239 дүгээр
тогтоолын 6 дугаар хавсралт

### СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮБД-1 | ТҮБД-2 | ТҮБД-3 | ТҮБД-4 | ТҮБД-5 | ТҮБД-6 | ТҮБД-7 | ТҮБД-8 |
| 1 | 214465 | 235911 | 271298 | 298428 | 313349 | 360352 | 396387 | 428296 |
| 2 | 216629 | 238292 | 274036 | 301440 | 316512 | 363988 | 400387 | 432579 |
| 3 | 222128 | 244341 | 280992 | 309091 | 324546 | 373227 | 410550 | 443394 |
| 4 | 236078 | 259685 | 298638 | 328502 | 344927 | 396666 | 424750 | - |
| 5 | 251640 | 276804 | 318324 | 350157 | 367664 | 422814 | 438949 | - |

Засгийн газрын 2010 оны 239 дүгээр
тогтоолын 7 дугаар хавсралт

### ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Салбарын зэрэглэл | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮЭМ-1 | ТҮЭМ-2 | ТҮЭМ-3 | ТҮЭМ-4 | ТҮЭМ-5 | ТҮЭМ-6 | ТҮЭМ-7 | ТҮЭМ-8 | ТҮЭМ-9 |
| 1 | 214465 | 235911 | 271298 | 298428 | 313349 | 360352 | 396387 | 428296 | 462560 |
| 2 | 216629 | 238292 | 274036 | 301440 | 316512 | 363988 | 400387 | 432579 | 467185 |
| 3 | 222128 | 244341 | 280992 | 309091 | 324546 | 373227 | 410550 | 443394 | 478866 |
| 4 | 236078 | 259685 | 298638 | 328502 | 344927 | 396666 | 424750 | - | - |
| 5 | 251640 | 276804 | 318324 | 350157 | 367664 | 422814 | 438949 | - | - |

Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолын 8 дугаар хавсралт

## СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮСУ-1 | ТҮСУ-2 | ТҮСУ-3 | ТҮСУ-4 | ТҮСУ-5 | ТҮСУ-6 | ТҮСУ-7 | ТҮСУ-8 | ТҮСУ-9 | ТҮСУ-10 | ТҮСУ-11 |
| 1 | 194526 | 204252 | 214465 | 235911 | 271298 | 298428 | 313349 | 360352 | 396387 | 428296 | 462560 |
| 2 | 196489 | 206314 | 216629 | 238292 | 274036 | 301440 | 316512 | 363988 | 400387 | 432579 | 467185 |
| 3 | 201477 | 211550 | 222128 | 244341 | 280992 | 309091 | 324546 | 373227 | 410550 | 443394 | 478866 |
| 4 | 214129 | 224836 | 236078 | 259685 | 298638 | 328502 | 344927 | 396666 | 424750 | - | - |
| 5 | 228245 | 239657 | 251640 | 276804 | 318324 | 350157 | 367664 | 422814 | 438949 | - | - |

Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралт

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(сард төгрөгөөр)

| Цалингийн сүлжээний шатлал | Албан тушаалын зэрэглэл | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТҮ-1 | ТҮ-2 | ТҮ-3 | ТҮ-4 | ТҮ-5 | ТҮ-6 | ТҮ-7 | ТҮ-8 | ТҮ-9 | ТҮ-10 | ТҮ-11 | ТҮ-12 |
| 1 | 182295 | 194526 | 204252 | 214465 | 235911 | 271298 | 298428 | 313349 | 360352 | 396387 | 428296 | 462560 |
| 2 | 184116 | 196489 | 206314 | 216629 | 238292 | 274036 | 301440 | 316512 | 363988 | 400387 | 432579 | 467185 |
| 3 | 188675 | 201477 | 211550 | 222128 | 244341 | 280992 | 309091 | 324546 | 373227 | 410550 | 443394 | 478866 |
| 4 | 200522 | 214129 | 224836 | 236078 | 259685 | 298638 | 328502 | 344927 | 396666 | 424750 | - | - |
| 5 | 213740 | 228245 | 239657 | 251640 | 276804 | 318324 | 350157 | 367664 | 422814 | 438949 | - | - |

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2010 оны 10 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 05 | Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 8 ДУГААР ЗҮЙЛ ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.50 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Н.Жанцан, Ж.Болдбаатар /илтгэгч/, Ж.Амарсанаа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Г.Агар-Эрдэнийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Бэхбат болон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан оролцов.

Хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Бэхбат Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:***

"Нийгмийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нийгмийн даатгал нь иргэн /цаашид "даатгуулагч" гэх/ болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, түүнчлэн даатгуулагч нас барахад түүний

асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн" гэж нийгмийн даатгалын үйлчилгээг, түүний дотор ажилгүйдлийн үйлчилгээг тодорхойлсон байна.

Үүнээс үзвэл Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалын байгууллага нь төрийн нэгэн үүргийг иргэний өмнө хүлээж даатгалын үйлчилгээг төрийн нэрийн өмнөөс иргэнд үзүүлдэг байна.

Тийм учраас төр иргэдийнхээ амьдралын баталгааг найдвартай хангах зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүн бүрийг нийгмийн даатгалд заавал хамруулахаар хуульчилжээ /Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/. Төр нэгэнт заавал даатгуулах үүргийг иргэндээ хуулиар оногдуулсан бол түүний эсрэг иргэнд үзүүлэх даатгалын үйлчилгээ нь гарцаагүй байх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг шударга ёсны зарчим мөн.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан "өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээ цуцалсан" болон "хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан" гэх шалтгаан нь даатгуулагчийн авбал зохих ажилгүйдлийн тэтгэмжийг хасах үндэслэл болох ёсгүй дээр "хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан" гэх шалтгаан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.3 дахь хэсэгт "Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулж болохгүй" гэж заасантай зөрчилдөж байна.

...Хэрэв төр нь даатгалын шимтгэлийг хураан авсан хэр нь даатгалын үйлчилгээгээ ямар нэг шалтгаанаар үзүүлэхгүй байх эсвэл хасах нь Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг шударга ёсны зарчим зөрчигдөхөд хүрнэ.

Мөн нийгмийн даатгалын байгууллага бол ажил олгогч биш, түүнд ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах хуулиар оногдсон эрх хэмжээ байхгүй...

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Нэгдүгээр

зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэснийг тус тус зөрчиж байна.

Үүний зэрэгцээ Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө" гэсэнд үндэслэн Монгол Улсын олон улсын зарим гэрээг үзвэл: Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй", 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...Ажилгүйдэх... шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй", Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд "Энэхүү пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө" гэсэн байна.

Энд мөн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэсэн Үндсэн хуулийн заалт болон Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 27 дугаар зүйлд "Оролцогч улс гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтыг баримтлан зааж үл болно" гэснийг харгалзан үзвэл Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэснийг зөрчиж байна." гэжээ.

***Хоёр. Иргэн Б.Бэхбатын мэдээллийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн урьдчилан шалгаад 2010 оны 7 дугаар сарын 2-ны өдөр 62 дугаар тогтоолоор маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзахдаа:***

"Улсын Их Хурал "Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль"-ийн 3 дугаар зүйлд уг зүйлд заасан тодорхой хэмжээгээр даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж олгохоор заасан нь энэхүү даатгалын төрөлд даатгуулагч "даатгалын үйлчилгээг гарцаагүй авах" хууль зүйн баталгаа болсон байна.

Харин уг хэмжээг хасах эсэх нь буюу дээр дурдсан хуулийн 8 дугаар зүйлд өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан, хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан даатгуулагчид олговол зохих тэтгэмжийн хэмжээг хасахаар заасан нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал болно. Олон улсын хэмжээнд тухайлбал, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1934 оны "Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай" 44 дүгээр Конвенцид адил төстэй зохицуулалт хийгдсэн байдаг байна.

1. Нийгмийн даатгалын байгууллага нь ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох үйл ажиллагааг эрхлэх чиг үүргийнхээ хүрээнд холбогдох даатгуулагчид хууль тогтоомжид заасан хэмжээ тус бүрээр тэтгэмж олгох нь Хөдөлмөрийн хуулийн холбогдох заалттай зөрчилдсөн гэх үндэслэлгүй бөгөөд хууль хоорондын зөрчилдөөн Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан биш болно." гэжээ.

***Гурав. Энэхүү тогтоолыг эс зөвшөөрч иргэн Б.Бэхбат Үндсэн хуулийн цэцэд дахин хандаж гаргасан гомдолдоо:***

"1. Тогтоолын "үндэслэл" хэсгийн 1-д "...өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан, хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан даатгуулагчид олговол зохих тэтгэмжийн хэмжээг хасахаар заасан нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал болно" гэсэн нь миний мэдээллээр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах үндэслэл болохгүй байна.

Учир нь аливаа хууль, хуулийн заалт нь Үндсэн хууль, Монгол Улс олон улсын гэрээгээр баталгаажиж, хамгаалагдсан хүний үндсэн эрх бодитой хэрэгжих эрх зүйн орчин болж чадсан тохиолдолд сая Үндсэн хуульд бүрнээ нийцсэн /Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1/ хууль, хуулийн заалт болж чадна. Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ бол хүний эрх, тэр тусмаа иргэний үндсэн эрхийг томъёолж бататгасан хууль зүйн эх сурвалж.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл хүний эрх, тэр тусмаа иргэний үндсэн эрхийг томъёолж бататгасан хууль зүйн эх сурвалжид бүрнээ нийцсэн байх шаардлагыг хангахгүй бол ажилгүйдлийн даатгалын үйлчилгээ нь төрийн албадлагаар хүний хөдөлмөрийг завшсан "хуульчлагдсан луйвар" болж

хувирах бөгөөд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан төрийн үүрэг хөсөр хаягдахад хүрнэ. Учир нь ажилгүйдлийн даатгал бол төлбөртэй үйлчилгээ. Хүн эрсдэл тохиолдсон үедээ хэрэглэх мөнгөө Нийгмийн даатгалын байгууллагад итгэн хадгалуулахдаа түүнтэй холбогдон үүсэх зардлыг шимтгэл нэрээр нийгмийн даатгалын санд /Нийгмийн даатгалын тухай хуулийн 2[1] дүгээр зүйлийн 3/ урьдчилан төлчихсөн байдаг.

2. Тогтоолын "үндэслэл" хэсгийн 1-д мөн "Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1934 оны Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай 44 дүгээр Конвенцид адил төстэй зохицуулалт хийгдсэн байдаг байна" гэсэн нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан тогтоолын үндэслэл болохгүй юм. Учир нь:

Монгол Улсын Гадаад харилцааны яамнаас өгсөн мэдээллээс /2010.07.26 №11/8078/ үзвэл Монгол Улс одоогоор дээрх конвенцид нэгдэн ороогүй, түүнийг соёрхон батлаагүй байна. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй", Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй" гэжээ.

3. Тогтоолын "үндэслэл" хэсгийн 2-д "...хууль хоорондын зөрчилдөөн Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан биш болно" гэсэн байна.

Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэж заажээ. Үүнээс үзвэл хууль нь өөр нэгэн хуультай зөрчилтэй байж болохгүй, харин өөр хоорондоо уялдаж байж Үндсэн хуульд нийцсэн байх шаардлагыг хангаж чадна. Өөр нэгэн хуультай зөрчилтэй хууль нь хууль зүйн эх сурвалжид томъёологдон баталгаажсан хүний эрх, тэр тусмаа иргэний үндсэн эрхийг хангаж чадахгүйн дээр төрийн байгууллага хүний эрхийг зөрчихөөс хамгаалж чадахгүй тул төрийн байгууллага хүний эрхийг зөрчихөөс хамгаалдаг Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт зөрчигдөх шалтгаан болно" гэжээ.

***Дөрөв. Иргэн Б.Бэхбатын гомдлыг Үндсэн хуулийн цэц Бага суудлын хуралдаанаараа хянан хэлэлцээд 2010 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 17 дугаар магадлалаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн бөгөөд уг магадлалын хянах хэсэгт:***

"1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд иргэний нийгмийн даатгалын үйлчилгээг гарцаагүй авах эрхийг хуульчлан баталгаажуулсан байна. Дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалтын нөхцөл нь Үндсэн хуулийн цэцийн маргааны шинжийг агуулж байна.

Иймд иргэн Б.Бэхбатын мэдээллээр Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх үндэслэлтэй байна." гэжээ.

***Тав. Монгол Улсын Их Хурлын даргын 2010 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 132 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

"...1...Хөдөлмөрийн тухай хуулийн бүх заалт болон үүний дотор хөдөлмөрийн сахилгын шийтгэлийн бүх хэлбэрүүдийг тогтоосон 131 дүгээр зүйл нь ажил олгогч буюу түүнийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтан болон ажилтан хоёрын харилцааг зохицуулж байгаа юм. "Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулж болохгүй" гэсэн Хөдөлмөрийн тухай хуулийн 131.3 дахь хэсгийн заалт нь мөн хуулийн 131.1 дэх хэсэгт заасан сануулах, үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, ажлаас халах гэсэн хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулах хэлбэрүүдэд хамаарна.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан "хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан нөхцөлд даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасах" тухай заалт нь сахилгын нэг зөрчилд хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж байгаа тохиолдол гэж үзэхгүй бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн дагуу ажилгүйдлийн тэтгэмж авах

эрх үүссэн даатгуулагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131.3 дахь хэсгийн заалт хамаарахгүй юм.

...Түүнчлэн, Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй байх нөхцөлийг хуулиар тогтоож болно" гэж заасан байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн энэхүү заалтыг баримтлан Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасанчлан ажилгүйдлийн тэтгэмжээс зарим хэсгийг олгохгүй байх нөхцөлийг хуульчилсан болно.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. ...Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй", 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй", Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн "Энэхүү пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө" гэснийг иш үндэс болгож, улмаар Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтыг баримтлан Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай зэрэг хуулийг батлан мөрдүүлсэн билээ.

Түүнчлэн 2001 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг баталсан юм. Энэ хуульд ажилгүйдлийн даатгалд хамрагчийн хүрээг өргөтгөх, иргэн бүрийг ажилгүйдлээс хамгаалах төрийн бодлого хэрэгжүүлэхээр тусгалаа. Энэ бодлогын хүрээнд ажилгүй, эсхүл ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах, хувиараа болон шинээр ажлын байр бий болгоход нь зориулан зээл олгох, улмаар ажилгүй иргэнийг авч ажиллуулсан ажил олгогчийг

дэмжих зэрэг үйл ажиллагаа явуулахаар заажээ.

...Монгол Улс нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагад 1968 онд гишүүнээр нь элссэн билээ. Тус олон улсын байгууллагын гишүүн орны хувьд манай улс тухайн байгууллагаас баталсан гэрээ, конвенци, зөвлөмжийг нь дагаж мөрдөх, дотоодын хууль тогтоомжоо тэдгээртэй нийцүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсээр ирсэн юм.

Улсын дээд шүүхээс 2008 оны 2 дугаар 28-ны өдөр баталсан 09 дүгээр тогтоолоор Монгол Улс олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай тайлбар гаргав. Тухайлбал, уйнхүү тайлбар ёсоор зөвхөн соёрхон баталсан олон улсын гэрээ дотоодын хуулиас дээгүүр хүчин чадалтай, харин Монгол Улсын хуулиар соёрхон батлаагүй олон улсын гэрээ түүнийг байгуулсан төрийн тухайн байгууллагын хууль тогтоомжийн эрхийн актуудаас дээгүүр хүчин чадалтай байхаар тус тус заажээ.

Үүнээс үзэхэд Монгол Улсын хуулиар соёрхон батлаагүй ч гэсэн Үндсэн хуульд харшлаагүй, олон улсын хэм хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн стандарт, хэм хэмжээг дагаж мөрдөх боломжтой байна.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэсэн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл үгүй байна.

3. ...Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхийг хангахуйц эдийн засаг, хууль зүйн болон бусад батлагааг төрөөс бүрдүүлж байгаа билээ.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд нийгмийн даатгалын төрөл тус бүрээр /тухайлбал тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн даатгалын зэрэг/ нийт 5 төрлийн мөнгөн хөрөнгийн сантай байхаар заасан юм. Нийгмийн даатгалын сангийн орлого нь даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоосоо төлсөн, ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоосоо төлсөн шимтгэлүүд түүнчлэн улсын төсвөөс олгох хөрөнгө зэрэг эх үүсвэрээс бүрдэж байхаар хуульчилжээ. Мөн хуулиар даатгуулагч, ажил олгогчоос ажилгүйдлийн

даатгалд тус бүр 0,5 хувиар шимтгэл төлөх юм.

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газраас авсан мэдээгээр бол 2009 оны байдлаар 11203 ажилгүй хүнд 6.1 тэрбум төгрөг олгосон байна.

Хууль зүйн баталгаа бүрдүүлсэн талаар энэ тайлбарт өмнө нь тодорхой дурдсан болно.

Иймхүү Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй болно." гэжээ.

***Зургаа. Иргэн Б.Бэхбат Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарт гаргасан хариу тайлбартаа:***

"Нэгдүгээрт:...Ажилгүйдлийн тэтгэмжийг хасах эсвэл олгохгүй байх нь төр иргэнийхээ шударга хөдөлмөрийг "луйвардаж" эсвэл иргэнээ боолчилж буй хэрэг болно. ...Иймд төрийн үйл ажиллагаа нь зайлшгүй шударга байх /Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2/ ёстой болж байна.

Учир нь Монгол Улсын иргэн хууль зүйн эх сурвалж болох Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд томъёологдон, батлагдсан хүний үндсэн эрхийн нэг "ажилгүйдлээс хамгаалуулах эрх"-ээ эдлэхээр өөртөө тусалж хуримтлал бий болоход оролцдог. Энэхүү хуримтлал бол хүний өөрийнх нь шударга хөдөлмөрийн үр шим, түүний өмч мөн.

Хоёрдугаарт: Зөвхөн хүний эрх л гэж бий. Түүнээс биш хамт олны ч юмуу, нийгмийн эрх гэж байхгүй. Тиймээс хувь хүний эрхээс өөр эрх угаас байхгүй хэрэв байх юм бол хэн ч эдэлж чадахгүйд хүрнэ. Иймд ажилгүйдлээс хамгаалуулах эрхээ эдлэх тухайд эв нэгдэл /солидарность/ яригдахгүй. Харин эрхээ эдлэхдээ бусдын эрхийг зөрчиж болохгүй тухай л яригдана...

Гуравдугаарт: Үндсэн хуулийн Дадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн бөгөөд "Мэдэгтүн, сахигтун!" хэмээн төгссөн байна.

Мөн Монгол Улсын олон улсын гэрээ болох Олон улсын гэрээний

эрх зүйн тухай Венийн конвенцийн 27 дугаар зүйлд "Оролцогч улс гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтыг баримтлан зааж үл болно" гэжээ.

Энд мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө" гэснийг дурдая.

Иймд Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг зөвтгөж боломгүй байна.

Хэрэв дээр дурдсан хууль зүйн эх сурвалжийг үл анхаарвал Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчих болно.

Дөрөвдүгээрт: Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон батласан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ", Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй" гэжээ.

Иймд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1934 оны Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай 44 дүгээр Конвенцийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх боломжгүй юм." гэжээ.

### ҮНДЭСЛЭЛ:

1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулсан байх бөгөөд уг зүйлийн 3 дахь хэсэгт "Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй байх нөхцөлийг хуулиар тогтоож болно" гэж заасны дагуу ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хэмжээг хасах нөхцөлийг тогтоох нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байна.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн

тухай хуулийн 8 дугаар зүйлд даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасахаар заасан нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС**
**ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан, эсхүл хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан нөхцөлд даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасахаар заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арвадугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ** **Ж.БЯМБАДОРЖ**

**ГИШҮҮД** **П.ОЧИРБАТ**
**Н.ЖАНЦАН**
**Ж.БОЛДБААТАР**
**Ж.АМАРСАНАА**

**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420, 329612
Хэвлэлийн хуудас 2
**Индекс: 14003**

